

**ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ХЭЛТСИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН
ТАСГИЙН 2023 ОНД ХИЙСЭН
АЖЛЫН ТАЙЛАН**

2023.12.05 өдөр

Сайнцагаан сум

2023 онд Дундговь аймгийн нийгмийн даатгалын хэлтсийн ХШДА-н тасаг нь Нийгмийн даатгалын хэлтсийн даргын НДЕГ-н даргатай байгуулласан гүйцэтгэлийн төлөвлөөгөөнд 3 арга хэмжээ, Дундговь аймгийн засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 2 арга хэмжээг хэрэгжүүлэн, тэтгэвэр, тэтгэмж тогтоолт, олголтонд хяналт тавьж ажиллаж байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ТАЛААР

Нийгмийн даатгалын салбарын “Цахим хяналтын веб програм”- (<http://10.9.0.5/monitoring>)-д тулгуурлан 2023 оны 13 төрлийн 1287 мэдээлэл зөрчилтэй мэдээллийг шалгаж зөрчлийг арилгасан.

Үүнд:


1. Цалин өөрчилсөн/АО/- 254
2. 01 код давхардсан -333
3. РД нэгтгэсэн-7
4. Ажил хийдэг тэтгэвэр авагч -103
5. Цалин өөрчилсөн/даатгуулагч/-170
6. Цалин устгасан-109
7. АЖ тэтгэмж авах хугацаандаа ажилласан-96
8. АЖ тэтгэмж цалинг хянах-8
9. АЖ тэтгэмж эрхийн нөхцөл хянах 2
10. ЖА тэтгэмж эрхийн нөхцөл хянах-7
11. ЖА тэтгэмж цалин хянах-131
12. Тэтгэвэр тогтоосон цалин хянах-9
13. Шимтгэл-даатгуулагчийн төрөл код буруу-58 зэрэг зөрчлүүдийг арилгаж хяналт шалгалтыг тогтмол хийж ажиллаж байна.

2023 онд аж ахуй нэгжийг шалгах төлөвлөгөөт шалгалтыг хэлтсийн даргын удирдамжийн дагуу 4 сарын 10-наас 9 сарын 30 өдрийн хооронд хийж 90 аж ахуй нэгжийг шалгасан. Шалгалтын зорилго нь нийгмийн даатгалтай гэрээтэй аж ахуй нэгжид нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилт, эрсдэлээс уридчилан сэргийлэх үүссэн зөрчил дутагдлыг арилгахаар хяналт шалгалтийг хийсэн. Мөн ажил олгогчийн тоот даатгуулагчийн өргөдөл гомдлын хүрээнд 27 аж ахуй нэгжийг шалгаж нийт 156,8 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тавьж 1 аж ахуй нэгжийн 148,5 сая төгрөгийн улсын байцаагчийн актыг шүүхээр баталгаажуулж шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэн авлага барагдуулах тал дээр хамтран ажиллаж байна.

2023 оны ажилгүйдлийн тэтгэмж дээр цалин тэтгэмжийг давхардуулж авсан 19 даатгуулагчийн 8,0 сая ,илүү олгосон 5 тэтгэвэр авагчид 9.1 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тавьж актыг 100% барагдуулсан байна. 11 аж ахуй нэгжид нийт 5,9 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан байна.


2023 оны жилийн эхний үлдэгдэл 743.3 сая төгрөгийн авлагатай байснаас энэ онд байдлаар 526,7 сая төгрөг барагдсан байна (График-1). 2023 оны 120 ба түүнээс дээш хоногийн насжилттай шимтгэлийн авлагын судалгааг гарган судалгаанд үндэслэн 1 аж ахуй нэгжид албан шаардлага хүргүүлж 1 аж ахуй нэгжийн 148,3 сая төгрөгийн авлагыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлж шат дараатай арга хэмжээ авч ажиллаж байна.

График 1



Тэтгэвэр тогтоолт, олголт:

2023 оны байдлаар дотоодын хяналт шалгалтаар сумын Тэтгэвэр, тэтгэмж тогтоолт, олголт, Нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийг цахим болон цаасан хэлбэрээр шалгаж 9.1 сая төгрөгийн төлбөр зөрчлийг илрүүлж гарсан төлбөрийг 100% барагдуулж ажилласан байна. Өмнөх оны тэтгэврийн улсын байцаагчийн актын 6.1 сая авлагаас 4.3 сая төгрөгийг актыг барагдуулсан байна. (График-2)



Тэтгэврийн авлага барагдуулалтын график

2023 оны байдлаар тус хэлтэст 8413 тэтгэвэр авагчид тэтгэвэр авч байна. Тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэрэг, хавсаргасан холбогдох үндсэн баримтын тооллогыг хагас, бүтэн жилээр хийж тооллогод хяналт шалгалт хийж ажилласан байна. 2023 оны жилийн байдлаар шинээр тэтгэвэр тогтоолгосон 493 / өн-376 ТД-98 ТА-19 /тэтгэвэр авагчийн тогтоолт олголтод хяналт тавьж ажилласан.

Монгол Улсын ХНХЯ-ын сайдын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/110 тушаалаар баталсан хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, ажилтан албан хаагчдийн ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангахад чиглэсэн хүүхэд хамгааллын бодлогын хүрээнд эцэг эхийн зөвлөлөөс санаачлан хэлтсийн ажилтан, албан хаагч нарын дунд хандивын аян өрнүүлэн 100 хувь хамт олны тусламж дэмжлэгээр “Хүүхэд хөгжлийн өрөө”-г тохижуулсан. Энэхүү хүүхдийн өрөөнд байгууллагын ажилтан албан хаагч нар болон хүүхдүүдийн уламжлалт тоглоом наадгайн мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор шатар даамны булан байгуулалаа.



Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар

Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан нь зөрчлийн тухай санал гомдол, өргөдлийг бүртгэж Прокурорын газарт сар бүрийн 28-нд мэдээг тогтмол хүргэж ажиллаж байна. 2023 оны байдлаар 1 ААН байгууллагад хяналт шалгалт хийж зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авч хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 1.6 сая төгрөгийн шимтгэлтийг төлүүлж 250. 0 мянган төгрөгийн торгууль оногдуулж, нөхөн төлбөрийг бүрэн барагдуулан ажилласан байна

Магадлагч эмчийн 2023 оны ажлын тайлан

Монгол Улсын засгийн газрын Эмнэлэг хөдөлмөрийн магадлах дүрэм шинэчлэн баталсан 67 тогтоол, “Эмнэлгийн хуудас олгох, хянах тухай” НДЕГ-н даргын 2021 оны А/38 тоот тушаал, “Даатгуулагч /иргэн/-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтооход баримтлах ердийн өвчний жагсаалт, хувь хэмжээ” –ийн тухай ЭМС, ХНХС-ийн А/758 А197 дугаар тушаалуудыг хэрэгжүүлэх талаар Аймгийн нэгдсэн эмнэлэг, өрх сумын эрүүл мэндийн төвийн эмч нар болон шинээр ажилд орсон сум өрхийн эмч нарт 10 удаагийн цахим сургалт зохион байгуулан давхардсан тоогоор нийт 55 эмч хамрагдсан.

Аймгийн Эрүүл мэндийн газар болон нэгдсэн эмнэлэгтэй хамтран осол, гэмтэл болон хөдөлмөрийн чадвар алдалтаас урьдчилан сэргийлэх талаарх сургалтыг аймгийн нэгдсэн эмнэлгээр үйлчлүүлж буй иргэдэд зохион байгууллаа. Сургалтанд нийт 50 иргэн хамрагдсан.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс 2022 оны 04 сарын 12 ны өдрийн А/66 тушаалаар шинэчлэгдэн батлагдаж ЭХМК-н дарга эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаарх хууль, тогтоомжийн биелэлтийг хангаж ажиллах талаар ЭХМК болон ЭХК-ийн дарга гишүүдэд зөвлөмж хүргүүлснээр ЭХМК-ийн гишүүдийн хуралд оролцох оролцоо, үүрэг хариуцлагыг жигдрүүлэн ажиллаж шийдвэр гаргалтанд гишүүн бүрийг оролцуулан олонхийн саналаар шийдвэр гаргадаг. Хурлын явцад гишүүдийн гүйцэтгэх ажил үүргийг хуваарилж хуралд оролцох оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэн ажилласнаар хурлын чанар дотоод үйл ажиллагаа жигд сайжирсан. Авлига ашиг сонирхлын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Хамаарал бүхий этгээдийн мэдэгдэх хуудас”-ыг ЭХМК-ийн гишүүдээр бөглүүлэн үйл ажиллагаандаа тогтмол хэрэгжүүлэн хэвшсэн.

Нарийн мэргэжлийн эмч нар болон өрх, сумын эмч нар ХЧА-тай иргэн даатгуулагчид тохирсон эрүүлжүүлэх төлөвлөгөөг гаргаж тухайн төлөвлөгөөний дагуу хийгдсэн эмчилгээ үйлчилгээний дагуу ЭХК болон ЭХМК үр дүнг тооцож ажилснаар эрүүлжүүлэх арга хэмжээ чанаржиж байна. Эмчлэн эрүүлжүүлсэн 98 иргэн даатгуулагч байна.

2023 онд нийт 50 удаа хуралдаж 1326 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын асуудлыг хэлэлцэн 108 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг цуцалж, 120 иргэн шинээр тогтоон 1108 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг сунгаж шийдвэрлэсэн байна. 35 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын үндэслэл хангалтгүй шалтгаанаар буцаасан байна.

Цахимаар эмнэлгийн хуудас илгээгдсэн сайн дурын даатгуулагчид хүсэлт хэрхэн илгээх зөвөлгөө мэдээллийг тогтмол утсаар зөвөлгөө өгч ажилласан.

2023 онд хөдөлмөрийн чадвар түр алдалтын 895 эмнэлгийн хуудсыг цахимаар, 34 эмнэлгийн хуудсыг цаасаар, жирэмсэн амаржсан 526 эмнэлгийн хуудсыг цахимаар, 33 эмнэлгийн хуудсыг цаасаар хянан тэтгэмжийн байцаагчид шилжүүлсэн байна. Цахимаар эмнэлгийн хуудас бичих аргагүйн зөвлөмжийг эхний хагас жилд 7 эрүүл мэндийн байгууллага /Хулд, Баянжаргалан, Дэлгэрхангай, Гурвансайхан, Цагаандэлгэр, Өндөршил, Эрдэнэдалай сумын эрүүл мэндийн төв/-ын эмч нарт, хоёрдугаар хагас жилд 3 эрүүл мэндийн төвийн /Өлзийт, Нэгдсэн эмнэлэг, Луус/ эмч нарт тус тус утсаар зөвлөмж өгч ажиллалаа.

2023 оны эхний хагас жилд нүд, чих хамар хоолой, дотор, мэдрэлийн нарийн мэргэжлийн эмч нарын дунд, 2023 оны хоёрдугаар хагас жилд мэс үасал, гэмтэл судлалын нарийн мэргэжлийн эмч нарын дунд ижил мэргэжилтний үзлэгийг тус тус зохион байгуулсан. Ингэснээр дээрх мэргэжлийн чиглэлээр эмнэлэг хөдөлмөр магадлах үйл ажиллагаанд оролцож буй эмч нарын зөрүүтэй ойлголт арилан, маргаантай асуудлыг шийдвэрлэн ажилласан.

2023 онд тус ЭХМК-т Сайнцагаан сумын ИТХ-аас ирүүлсэн өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэн хариуг хүргүүлсэн.

2023 оны 3 сард “Жендэрийн ялгаварлан гадуурхалт ба жендэрт суурилсан хүчирхийлэл”, “Жендэрт ба хөгжлийн бэрхшээлийн талаарх ойлголт, хандлага”, 4 сард Хүний эрхийн үндэсний комиссоос зохион байгуулсан “Хүний эрх эрх чөлөө, Хүний эрхийн түгээмэл тунхаглал”, “Эрүүл амьдрах ухаан”, “Монгол бичгийг албан хэрэг хөтлөлтөнд хэрхэн ашиглах”, “Стандарт ба эрсдэл” зэрэг сургалтанд тус тус хамрагдсан.

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ

А.ЦЭГМЭДБААТАР 2023ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН

Нэг. Ерөнхий мэдээлэл

Иргэд даатгуулагчдын хөдөлмөрлөх эрх, нийгмийн баталгааг хангуулах, сангийн хөрөнгийн зарцуулалтыг сайжруулах зорилгоор хяналт шалгалт, зөвлөн туслах, урьдчилан сэргийлэхэд үйл ажиллагааныхаа ихэнх хувийг чиглүүлж, ажилтнуудын нийгмийн хамгаалалтай холбоотой зөрчлийн бууралт, сангуудын бүрдүүлэлт, зарцуулалтын зөрчлийн бууралт, тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголтын зөрчилд хяналт шалгалтыг хийх зөвлөн тусалж хууль, дүрмийг сурталчлахад анхаарч ажиллалаа.

Хоёр. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

2023 онд нийт 6 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж ажилласнаас биелэлт дунджаар 100% хувь байна.

Төлөвлөсөн арга хэмжээний нийт тоо	Биелэлтийн хувь						Биелэл-тийн дундаж хувь
	100%	70%	50%	30%	10%	0%	

14	13	1					97%
----	----	---	--	--	--	--	-----

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үр дүнгийн талаарх дүгнэлт:

Жилийн эцсийн байдлаар гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнээс төлөвлөгөөт шалгалт удирдамжийн дагуу 10 аж ахуйн нэгжид, урьдчилан сэргийлэх шалгалт 3 хяналт шалгалт хийсэн.

Гурав. Хяналт шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилт

Төлөвлөсөн арга хэмжээний тоо	арга нийт	Биелэлтийн хувь						Биелэл-тийн дундаж хувь
		100%	70%	50%	30%	10%	0%	
14	13	1					97%	
-								

Хяналт шалгалтын гүйцэтгэлийн үзүүлэлт:

Хяналт шалгалтад хамрагдсан объектын тоо:	2023 оны		Гүйцэтгэлийн хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Төлөвлөгөөт шалгалт	12	10	80%
Урьдчилан сэргийлэх шалгалт	3	3	100%
Нийт объектын тоо	15	13	86%

Дүгнэлт: Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 3 объектод хийж илэрсэн дутагдлыг арилгуулхаар улсын байцаагчийн акт 1-ийг тогтоож биелэлтийг хангуулсан.

Улсын байцаагчийн авсан арга хэмжээ:	Тогтоосон	Биелэлт хангагдсан	Биелэлтийн хувь
• Нөхөн төлбөр /мян.төг/	534,857	534,857	100%
○ Тогтоосон	534,857	534,857	100%

○ Барагдуулсан	534,857	534,857	100%
●			
○			
○			
Улсын орлого болгосон /мян.төг/	-		
Хурааж устгасан /мян.төг/	-		
Үйл ажиллагааг нь зогсоосон объектын тоо			
Урьдчилан сэргийлэх шалгалтаар 1 акт тогтоож 534857 төгрөгийг нөхөн төлбөрийн акт оногдуулсан. Актын төлбөрийг 100% барагдуулсан.			

Хяналт шалгалтын ажлын үр дүнгийн талаарх дүгнэлт:

Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр тогтоолгон авч байгаа иргэд, мөн хугацаанд Нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр тогтоолгон давхардуулан авч байгаа эсэхийг, Нийгмийн халамжийн сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021-2022 оны бүрдүүлэлт, зарцуулалтад төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж хууль тогтоомжийн биелэлт дунджаар 95%-тай байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДОТООД АУДИТЫН ТАСАГ